



Г.ЭРДЭМЭЭ

Удирдлагын Сургуулийн
профессорын багийн
ахлагч, профессор,
хурандаа

ЭРТНИЙ ЭНЭТХЭГИЙН ШОРОН.

(цуврал өгүүлэл)

Дэлхийн эртний төрт улс орнуудад гяндан хэлбэрийн шоронгууд байсан талаар Норвал Моррис өөрийн бүтээл “Хорих ялын ирээдүйн байдал”¹⁵⁵ номондоо тэмдэглэн үлдээжээ. Мөн сэргэн мандалтын үеийн Европт бий болж хэрэглэгдсэн байцаан шийтгэх аргын тухай өгүүлдэг. Энэхүү аргыг Ром, Египет, Хятад, Энэтхэг, Сир болон Вавилонд өргөнөөр хэрэглэдэг байв. Гэхдээ шоронд хорих ял нь тусгай шийтгэл болохын хувьд харьцангуй сүүлд үүссэн гэж үздэг.

Одоогийн бидний ойлголтоор шорон нь зөрчил гаргагчийн шүүх хурал болон ял шийтгэл оногдуулахыг хүлээх хооронд “Түр саатуулах байр” гэсэн утгаар анх гарч иржээ. Гэхдээ ихэнх орнуудын хэрэгжүүлж эхэлсэн нь тийм ч таатай бус нөхцөлд гэр бүл болон нийгмээс тусгаарлан хорих явдал нь хуучны бие махбодыг тарчлаан зовоох шийтгэлийг оролж чадсан ялын тохиромжтой хэлбэрт тооцогддог байв.

Түүнчлэн хорих ял нь 2 зорилготой бөгөөд үүнд гэмт хэрэгтэнд шударгаар ял ноогдуулах, мөн түүнийг болон өөр бусад адил төстэй үйлдэлтэй хүмүүсийг

хорьж саатуулах замаар нийгмийг хамгаалах явдал юм. Шинэчлэгдсэн шоронгуудын хувьд агааржуулалт, хангалт муутай эртний гяндангуудаас тийм ч ялгаатай байгаагүй юм. Ашиг олохыг хичээсэн хувь хүмүүс шоронгуудыг удирддаг байсан нь хахууль болон харгислалыг бий болгож байсныг бид өмнөх илтгэлд дурьдсан.

Нийгмийн ажилтнуудын шоронгийн сэтгэл өвтгөм нөхцөл байдлыг тодотгосон бичвэрүүдийн нөлөөгөөр аажмаар улс орнуудын засгийн газар нь шоронг өөрийн удирдлага болон хяналтандаа авсан юм. Гэмт хэрэг үйлдсэн, зөрчил гаргасан этгээдийг нийгмээс тусгаарлах болон хорих арга хэмжээ нь гэмт хэрэгтэнг засан хүмүүжүүлнэ гэж итгэдэг байжээ. Гэсэн хэдий ч өмнөх туршлага нь энэ горьдлогыг худлаа гэдгийг харуулсан бөгөөд ихэнх тохиолдолд хорих ял нь гэмт хэрэгтэнд эсрэг нөлөөг үзүүлж байв.

Зан байдлын шинжлэх ухааны хөгжихийн хэрээр гэмт хэрэгтний засрал нь ганцаар хорьсноор засрагдахгүй гэдэг нь нотлогдож байлаа.

Залхаан цээрлүүлэх болон хорих уламжлалт арга нь аажмаар нийгмийн хамгаалалт болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэлт гэсэн орчин үеийн үзлээр солигдсон юм.

18-р зууны эцэс хүртэл Английн тэр үеийн шоронгууд нь гэмт хэрэгтнүүдийн үхээгүй л гарсан бол нийгмийн тахал болон хувирдаг хэмээн үзэж иржээ. Мөн тухайн газрыг тэр үзлээр дүрслэн бодож байсан байна.

¹⁵⁵ The future of imprisonment. By Norval Morris.* Chicago: TheUniversity of Chicago Press. 1974. Pp.xiv, 144.




Жон Ховард¹⁵⁶ хүчин чармайлтын үр дүнд 1824 онд Их Британийн парламентаас ёс зүйт шоронгийн захиргааны тухай хамгийн анхны бичиг баримтыг гаргасан юм. Түүнээс хойш шоронгийн хөгжил нь Их Британид тасралтгүйгээр урагшилсаар Европын ихэнх орнууд болон Америкийн нэгдсэн улсад их бага хэмжээгээр нөлөөлж дэлгэрсэн билээ.

Эртний Энэтхэгийн шоронгийн тогтолцоо

Энэтхэгийн эртний шоронгууд нь эртний төрт улсуудад байсантай адил гэмт хэрэгтний шүүх хурал, шүүхээс гаргах ялын тогтоолоо хүлээн саатуулагддаг газар байлаа. Тухайн

¹⁵⁶ Джон Говард (англ. John Howard, 1726.09.02-нд Лондонд төрсөн, 1790.01.20-нд Херсонд нас барсан) — английн хуульч, нигүүлсэгч ба английн анхны шоронгийн шинэтгэгч, европ дах нийтийн халдварт өвчний судлаач.

үеийн Энэтхэгийн нийгмийн бүтэц нь “Манугийн хууль”¹⁵⁷ -аар илэрхийлэгдэж, Яжна Валкя, Каутилья¹⁵⁸ болон өөр бусад түүхэн хүмүүсийн тайлбарласан зарчмууд дээр үндэслэгдэнэ.



Чанакья Пандит

Хорих ял нь эртний Энэтхэгийн пенологит¹⁵⁹ тамгалах, дүүжлэх, гэмтэл

¹⁵⁷ Манугийн хууль-санскрит хэлээр бичигдсэн. МЭӨ I зууны үед зохиогдсон. Нийт 2685 зүйлтэй, 12 бүлэгтэй, домогт бурхан Манугийн нэрээр нэрлэгдсэн. Ж.Цэцэгмаа. Гадаад орнуудын төр, эрх зүйн түүх. УБ хот.: “ADMON” ХХК, 2007 он. ISBN 99929-0-378-3. 32-р тал

¹⁵⁸ Домогт ярьдагаар Каутелья МЭӨ IV зуунд Таксила хотод алдартай угсаатны гэр бүлд төржээ. В.И.Маршев. “Удирдлагын үзэл санаа”-ны түүх: Сурах бичиг – М.Инфира-М, 2005. -737 хуудас.

Судлаачид Чанакья (санскр. चाणक्य Cāṇakya, МЭӨ 370—283 он) гэдэг нь жинхэнэ нэр бөгөөд Каутилья, Вишнугупта болон Ватсьяяна нэртэй байсан гэдэг. Эртний энэтхэгийн I-р Чандрагупта хааны зөвлөх сайд, брахман. <https://ru.wikipedia.org/wiki/Чанакья>

¹⁵⁹ Penology-гэмт хэрэгтэнтэй харилцах харьцаа, шоронгийн зохицуулалтыг судалдаг криминологийн салбар шинжлэх ухаан. Пенологийн судалгаа нь яллах үндэслэл, нотолгоо болон ял оногдуулж байгаа нийгмийн

бэртэл¹⁶⁰ болон үхэх¹⁶¹ гэх мэт олон төрлийн бие махбодын шийтгэлүүдээс хамгийн хүлцэнгүй ялын төрөлд ордог. Эрүүгийн шийтгэлүүд дундаас хорих ял нь энгийн зүйлд тооцогдох бөгөөд муу зүйл хийсэн хүнийг нийгмээс тусгаарлаж шоронд хийх энэ төрлийн бие махбодын шийтгэл хэрэглэхийг эртний энэтхэгийн ном шаштирт санал болгосон байдаг.

Хорих ялын гол зорилго нь буруу зүйл хийсэн хүмүүсийн гэмт үйлдэл нь нийгмийн бусад гишүүдэд нөлөөлөхөөс урьдчилан сэргийлж, нийгмээс салган тусгаарлах явдал байлаа. Шоронгууд нь бүхэлдээ харанхуй, хүйтэн, чийгтэй, гэрэлтүүлэггүй, халаалтгүй байрууд байх бөгөөд ариун цэврийн зохистой зохицуулалтгүй, хүн амьдрахад тохиромжтой нөхцөл байсангүй.

Хэдийгээр түүхэн баримтуудаас тухайн цаг үед дүгнэлт хийхэд тов тодорхой дүрслэлийг өгж байсан ч энэтхэгийн хууль тогтоогчид нь шоронгийн амьдралын талаар тун бага

зорилгыг тодорхой болгох, үндэстэн ба түүхэн үе хоорондын ялын хууль ба шийтгэлийн ялгааг тогтоох, тухайн үеийн хүчинтэй байгаа бодлогын нийгмийн уршгийг тодорхойлох зорилготой болно. Үүнтэй холбоотой нөлөө бүхий түүхэн бүтээлүүдийн жагсаалтад Сэсар Бэскарын “Гэмт хэрэг ба шийтгэлийн тухай” (on crimes and Punishments, 1974), Жэрэми Бентамын “Паноптикон” бүдүүвч (1800 оны үе), Сэсар Ломбросогийн “Гэмт хэрэг” (Crime, 1876), Мишель Фукогийн “Сахилга бат ба шийтгэл” (Discipline and Punish, 1975)

Britannica ширээний нэвтэрхий толь 5. NEPCO ISBN 978-99962-66-20-1

¹⁶⁰ бие эрхтэнийг нь гэмтээх (хуруу хөл, гарыг нь тасдах) Ж.Цэцэгмаа. Гадаад орнуудын төр, эрх зүйн түүх. УБ хот.: “ADMON” ХХК, 2007 он. ISBN 99929-0-378-3. 35-р тал

¹⁶¹ янз бүрийн аргаар (гадсан дээр суулгах, орон дээр нь буюу түүдэг гал дээр шатаах, живүүлэх, нохойгоор бариулах гэх мэт) цаазлах. Мөн тэнд 35-р тал

ойлголттой байснаас цөөхөн хэдэн шаштир¹⁶² бичээч нар л зарим нэгэн ял шийтгэл, шоронтой холбоотой мэдээллийг тэмдэглэн үлдээжээ. Тухайлбал Яжнавалкья¹⁶³ нь гэмт хэрэгтэнд зугтахад тусалсан хүнд цаазаар авах шийтгэлийг хүлээлгэх хэрэгтэй хэмээн өгүүлсэн бол хүний нүдийг гэмтээсэн хүнд хорих ял оноохыг Вишня¹⁶⁴ санал болгосон байдаг.



I-р Чандрагупта хааны зөвлөх сайд Каутилья нь шоронг нийслэл хотод барихаас гадна эрэгтэй, эмэгтэй хүмүүст зориулсан тусдаа байрыг бэлтгэх ёстойг онцлон тэмдэглэжээ.

Тэрээр гэмт хэрэгтнүүдийн амьдрал болон тэдний нийгмийн халамжийн талаарх асуудлыг чухалчлан анхаарч, тодорхой нөхцөл хангасан, тэмдэглэлт өдрүүдийг тохиолдуулан хорих ялтай этгээдүүдийг суллаж нийгэмд эргэн орох боломжийг нээж өгч байжээ. Тухайлбал:

1. Торгуулийг мөнгөн хэлбэрээр төлсөн, бие махбодын дундаж шийтгэлийг хүлээсэн эсвэл нийгмийн хөгжлийн төлөө ажиллана гэж амлалт

¹⁶² Smriti-ам дамжин ирсэн шаштир туульс

¹⁶³ Ведийн төлөөлөгч

¹⁶⁴ Энэтхэгийн бурхны таван гол дүрийн нэг

өгсөн хоригдлуудыг хоригдсоноос хойш тав дахь өдөр болгон суллах,

2. Ханхүү мэндлэх эсвэл хааны өв залгамжлагчийг хаан ширээнд залах ёслолын үеэр ерөнхий өршөөлийг хэрэгжүүлэх, нийтийн уламжлалт баярууд нь бусдын анхаарлыг татаж чадахуйц өршөөлд зориулсан зөв шалтгаан болж чадах тул өршөөл гаргах

3. Хоригдож буй өвчтэй болон өнчин хүмүүст, хянаж буй шоронгийн даргын төрсөн өдрийг тохиолдуулан хоригдлуудыг чөлөөт иргэд болгон суллах гурав дахь шалтгаан байсан нь сонирхолтой.

Ингэснээр хоригдлууд шоронгийн хилийг даван гадагш гарах мөн хотын иргэдэд хамаарах чөлөөт хуулийн дагуу амьдрах эрхтэй болж байлаа.

Каутилья мөн түүнчлэн хоригдлуудын хөдөлгөөн бүрийг үргэлж хянаж байдаг шоронгийн харгалзагч нар болон шоронгийн удирдлагуудын зөв үйл ажиллагааны талаар журамлан заажээ. Хэрэв хоригдол ямар нэгэн аргаар өөрийн хорих өрөөнөөс гарч явсан тохиолдолд түүнийг 24 рупигээр торгох ба тухайн хэсгийн шоронгийн хянагчийг үүнээс хоёр дахин илүү хэмжээгээр торгоно. Хэрэв шоронгийн хянагч шоронгийн үйл ажиллагаанд ямар нэг хэмжээгээр саад учруулвал, дээд удирдлага нь түүнд торгууль болох 500 рүпи оногдуулна. Заримдаа хоригдол нь шоронгийн хянагчийн буруугаас болж үхэлд хүрсэн тохиолдолд хамгийн өндөр шийтгэл буюу 1000 рупигээр торгуульна. Каутилья нь шоронгийн амьдралын гүнрүү нэлээд орсон нь

шоронгийн ханыг эвдэн оргосон хоригдол үхэх ял хүлээх саналыг тэрээр гаргаж байлаа. Эдгээрээс Бандханагарадхякса хэмээн нэрлэгддэг шоронгийн удирдлага үргэлж сонор сэрэмжтэй байж, тэдний хараанаас ямар ч зүйл мултрах аргагүй байсан нь илэрхий.

Ашокийн¹⁶⁵ бүр эхэн үеийн жилүүдэд хуучны бие махбодийг тарчлаан зовоох харгис аргыг ноогдуулдаг, тэндээс ганц ч хүн амьд гарах боломжгүй шорон байсан юм. Гэхдээ түүний төрийн эрх барьж байсан сүүлийн жилүүдэд буддизмийн нөлөөтэйгээр гаргасан ёс суртахууны зарчмуудад засан хүмүүжүүлэх олон арга хэмжээ авсан нь тусгалаа олжээ. Профессор Рам Чандра Дикхитар¹⁶⁶ “Маурийн төрийн

¹⁶⁵ Asoka-МЭӨ 304 онд төрж, 232 онд нас барсан. Буддын шашныг тэтгэгч, энэтхэгийн маурийн эзэнт гүрний сүүлийн аугаа хаан. Калингаг цус асгаруулан байлдан дагуулж захирснаасаа найман жилийн дараа цэрэг дайны түрэмгийллээс татгалзан дарма-ийн ёсоор амьдрах шийдвэр гаргажээ. Тэрээр буддын шашны тухай зөвхөн буддын шашинтнуудтай ярихын зэрэгцээ бусад шашинд хүлцэнгүй хандах улс төрийн бодлого баримталсан юм. Баганан дээрх зарлиг, Чулуун дээх зарлиг хэмээн алдаршсан хоёр зарлигаараа дамжуулан буддын шашны сургаалыг дэлгэрүүлж байлаа. Тэрээр түшмэддээ хүмүүсийн гачигдал дутагдлыг харгалзан үзэж, хуулийг шударга хэрэгжүүлэхийг зарлиг болгосны дээр дармагийн сайд нартаа зовсныг илтгэж бусад шашин, эмэгтэйчүүд, алслагдмал нутаг болон хөрш хүн ардын гойд ядуу зүдүүд нь туслахыг тушаажээ.

¹⁶⁶ Вишнампет Р. Рамачандра Дикшитар (англ. Vishnampet R. Ramachandra Dikshitar; тамил хэлээр. ராமச்சந்திர தீக்ஷிதர்; 1896.04.16 — 1953.11.24 хүртэл) — энэтхэгийн тамилын түүхч, индолог, дравидолог ба санскрит судлаач. Тэрээр энэтхэгийн судлах шинэ аргачлалыг гаргасан байна.

бүтэц”¹⁶⁷ нэртэй өөрийн номондоо Ашока Артхашастраг¹⁶⁸ мэддэг байсан бөгөөд хаан сэнтийд заларснаас хойших 26 жилийн туршид шорон руу илгээсэн хорин таван хэрэгт түүний нөлөөлөл байсан гэдгийг тэмдэглэсэн байдаг.

Ашокагийн дараах үед Жатаканууд нь нийгэм болон гэмт хэрэг, хорих ялтай холбоотой мэдээллүүдийн талаарх зураглалыг үлдээжээ. Сея Жатакад \283-д\ хаан нэгэн түшмэлээ барьж, шоронд хорьсон тухай өгүүлдэг. Гэхдээ түүний гэмгүй үйлдлийн талаар хаанд мэдэгдэхэд хаан тэрхүү түшмэлийг шоронгоос суллан тавьдаг. Өөр нэгэн Жатакад \210-д\ дайн болон цэрэг татлагийн үеэр улс төрийн хоригдлуудыг суллаж цэрэгт явуулдаг байсан тухай гардаг. Эртний Энэтхэгт хоригдлуудыг суллах явдал нь нийтлэг шинж чанартай байсан юм.

Хоригдлуудын нөхцөл байдал хангалтгүй байсан тухай Харшачаритаас¹⁶⁹ харагддаг. Эртний Хятадын аялагч Сюань-Цангийн тэмдэглэлд хоригдлууд ихэнхдээ маш хүнд хэлбэрийн шийтгэл хүлээдэг байсныг тэмдэглэн үлдээсэн юм. Тэдэнд сахал, үсээ хусах хориотой байснаас үслэг нүүр, ширэлдсэн сахалтай байв. Гэсэн хэдий ч тэр үед хоригдлуудыг сулладаг шалтгаанууд байжээ. Хаан нь тэрсүүд өдөр төрсөн тохиолдолд зурхайчид нь бүх хоригдлуудыг суллахыг зөвлөсөн тухай Калидаст тэмдэглэгдэн үлдээжээ. Мөн

хаан ширээнд залах ёслолын үеэр бүх хоригдлуудыг суллаж чөлөөлжээ. Тэрч бүү хэл Брхат Самхита нь хааны ариун угаалгын ёслолын үеэр хоригдлуудын суллах зарлиг гаргасан тухай нэмж бичсэн байдаг.

Эртний түүхэн өгүүллүүд нь архелогийн эх сурвалжаар баталгаажсан юм. Энэтхэгийн археологийн тэнхимээс гаргасан Ражгир нэртэй товхимолд Бимбизарагийн шоронг гол замын дагуу урагшаа явж, Маниур Матаагаас 2км орчим яваад, булан болгондоо 1м² өргөнтэй дугуй хэрэм бүхий, 60м² чулуун ханатай газарт очно гэж дүрсэлэн заадаг. Энэ газар Бимбисарагийн өөрийн хүү болох Ажатаватругийн тушаалаар хоригдсон шорон гэдгээрээ нийтэд танигдсан. Мөн Бимбисара шоронгоос Гридхракутра дээрх буддааг харах боломжтой байсан тухай өгүүлсэн байдаг. Шоронгийн нэг хэсэг нь хоригдлуудын баривчлахад зориулсан байсан бөгөөд энэ нь төгсгөл хэсэгтээ гогцоологдсон төмөр цагирагтай тусгай өрөө байв.

Шоронгийн түшмэлүүдийг Бандханагарадхякса болон Карака гэж нэрлэх бөгөөд эхнийх нь шоронгийн захирагч, удаах нь түүний туслахуудын нэг юм. Сангийн сайдын мэдэл доор байсан шоронгийн захиргаа нь хэрэгцээт барилгыг барих болон тухайн газрын байршлыг сонгох үүрэг хүлээнэ.

Дээрх байдлаас үзвэл эртний Энэтхэгийн шоронгийн тогтолцоог одоогийн шоронгийн тогтолцоотой харьцуулахад эртний Энэтхэгт тогтмол шоронгийн тогтолцоо байгаагүй бөгөөд

¹⁶⁷ Dikshitar V. R. Ramachandra. The Mauryan Polity. — 1932

¹⁶⁸ Эртний Энэтхэгийн улс төр, эдийн засгийн хууль журам

¹⁶⁹ Энэтхэгийн эзэн хаан Харшагийн намтар